



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 85

Хэрлэн сум

Баянхутаг сумын эрүүл мэндийн
төвийн даргын сул орон тоонд
томилуулахаар нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтад /62/ оноо авч, тэнцсэн Алтангэрэлийн Сувд-Эрдэнийг Баянхутаг сумын эрүүл мэндийн төвийн даргын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч А.Сувд-Эрдэнийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Баянхутаг сумын Засаг дарга (Б.Амгаланбат)-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Баянхутаг сумын Засаг даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР